



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 онь 05 сарын 19 өдөр

Дугаар А/244

Хэрлэн сум

Ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах
худалдан авах ажиллагааг зохион байгуулах
үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.5 дахь хэсэг, 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь заалт, 50 дугаар зүйлийн 50.1.2, 50.3, 50.4, 50.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжих Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх хүрээнд “Хамгаалалтын ойн зурвас байгуулах (Баянмөнх, Дархан, Галшар сумд)” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны

дарга:

Ц.Бат-Эрдэнэ

Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө
оруулалтын хэлтсийн мэргэжилтэн

Нарийн

бичиг:

Б.Должинсүрэн

Худалдан авах ажиллагааны газрын
мэргэжилтэн

Гишүүд:

Д.Оюун

Төрийн бус байгууллагын төлөөлөл

2.Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж ажиллахыг
Үнэлгээний хорооны дарга (Ц.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.АЮУРБУНЬ

